



ХИЛ СУДЛАЛ

ХИЛИЙН БООМТОД ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕИЙН ХАРИЛЦАН АЖИЛЛАГАА

COOPERATION DURING EMERGENCIES AT BORDER CROSSING POINTS

Д.Ариунболд

Удирдлагын академийн суралцагч, хошууч

Ariunbold D.

Student of the Leadership Academy, Major

*хариуцлагатай зохиогч: bbold6796@gmail.com

Хураангуй: Хилийн боомт нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүний урсгалыг зохицуулах үндсэн үүрэгтэй бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах стратегийн чухал цэг юм. Гэвч дэлхий дахинд геополитикийн нөхцөл байдал өөрчлөгдөж, хил дамнансан гэмт хэрэг, хууль бус наймаа, халдварт өвчин зэрэг аюул нэмэгдэхийн хэрээр хилийн боомтын аюулгүй байдалд сөрөг нөлөөлөх хүчин зүйлс улам бүр олон төрлөөр илэрч байна. Судалгаанд хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлөх гадаад болон дотоод хүчин зүйлсийг шинжилж, төрийн байгууллагуудын харилцан ажиллагаа, хуулийн зохицуулалтын ач холбогдлыг тодорхойлсон болно. Үр дүнд нь хилийн боомтын аюулгүй байдлыг хангахын тулд эрх зүйн уялдаа холбоог сайжруулах, байгууллагуудын харилцан ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Abstract: The border checkpoint plays a strategic role in ensuring national security by regulating the movement of passengers, vehicles, and goods across the state border. In recent years, the changing geopolitical environment, the rise of transnational crime, illegal trade, and the spread of infectious diseases have increasingly posed multifaceted threats to border security. This study analyzes the internal and external factors influencing the emergence of emergency situations at border checkpoints and examines the significance of inter-agency cooperation and legal coordination in addressing these challenges. The research findings reveal that ensuring the safety and stability of border checkpoints requires strengthening the legal framework, improving inter-organizational coordination, and enhancing institutional capacity for effective risk prevention and crisis management.

Түлхүүр үгс: Хилийн боомт, боомт аюулгүй байдал, онцгой нөхцөл байдал, харилцан ажиллагаа

Keywords: Border checkpoint, border security, state of emergency, tradition, Inter-agency cooperation.

Удиртгал

Монгол Улсын хил бол тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа бөгөөд хилийн боомт нь улсын эдийн засаг, аюулгүй байдал, гадаад харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хилийн боомт нь аливаа улсын гадаад ертөнцтэй материаллаг байдлаар харилцах үндсэн хэрэгсэл болохын хувьд улс төр, нийгэм, эдийн засаг, худалдаа, соёл, иргэд хоорондын харилцаанаас гадна аюулгүй байдлын асуудал гагцхүү хилийн боомт, түүний дэд бүтцээр дамжин явагддаг.

Хилийн боомтод явагддаг үйл ажиллагаа нь олон улсын худалдаа, аялал

жуулчлал, тээвэр логистикийн урсгалыг хянах төдийгүй улс орны аюулгүй байдлыг хангах анхны шугам юм.

Гэвч хилийн орон зайн нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хөрш орнуудын бодлогын нөлөө, хууль бус үйлдэл, байгалийн болон хүндрэлтэй нөхцөл байдал зэрэг хүчин зүйлс нь боомтын хэвийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэдэг. Иймээс хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлж буй дотоод, гадаад хүчин зүйлсийг судлах нь хил хамгаалалтын бодлого, төрийн байгууллагуудын хамтын



ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Энэхүү өгүүлэлийн зорилго нь Монгол Улсын хилийн боомтын аюулгүй байдал, боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлон, тэдгээрийн шинж чанарыг ангилж, төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцооны үүргийг тодорхойлон үнэлэлт, дүгнэлт өгөхөд оршино.

Үндсэн хэсэг

Хилийн боомт нь улс орны аюулгүй байдал, эдийн засаг, олон улсын харилцааны чухал төв цэгүүдийн нэг бөгөөд өдөр тутам олон мянган зорчигч, ачаа тээврийн урсгалыг зохицуулж байдаг. Гэвч тодорхой нөхцөл байдлуудаас шалтгаалан боомтын үйл ажиллагаанд саад учрах, бүрэн зогсох эрсдэлтэй байдаг. Үүнд байгалийн гамшиг, цар тахал, хүн, тээврийн хэрэгсэл барьцаалах, террорист халдлага, хууль бус үйл ажиллагааны эрсдэл зэрэг олон хүчин зүйл нөлөөлж болно.

Аливаа объект руу хүмүүс нэвтрэх, тээврийн хэрэгсэл, ачаа барааг оруулан гаргах үед тэдгээрт хяналт тавих, шалгах зориулалттай, тодорхой эрх бүхий субъектүүдээс бүрдсэн, тусгай тоног төхөөрөмжтэй, хамгаалалттай газрыг шалган нэвтрүүлэх цэг, байр гэдэг түгээмэл ойлголт нийт иргэд, дэлхий даяар байдгийг бид мэдэх билээ. Харин объект гэдэг нь байгууллага, яам тамгын газраас авхуулаад үйлдвэр, тусгай газар, цэргийн анги, салбар, цаашлаад улс орны нутаг дэвсгэр бүхэлдээ багтаж байдаг зүй тогтолтой. Тиймээс эдгээр объект руу нэвтрэхдээ заавал зориулалтын газар буюу шалган нэвтрүүлэх цэг, байраар нэвтэрдэг, үүний тулд зөвшөөрөгдсөн баримт бичиг, үнэмлэх биеийн байцаалт хэрэгтэй байдаг аж. (Х.Асхар, 2024)

Манай улсын өнөөгийн мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүдэд хилийн боомтыг дараах байдлаар томъёолсон байна: Үүнд:

- Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай

түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зориулалтаар тусгайлан тогтоож, төхөөрөмжилсөн газар; (М.Ганболд, 2010)

- Хилийн тухай хуулийн 3.1.12 дугаар зүйлд хилийн боомтыг тодорхойлсон; (Хилийн тухай хууль, 2016)

- “Хилийн боомт” болон “Боомт” нь адил утгатай байх бөгөөд Монгол, Хятадын хилийн 2 талд орших иргэд, тээврийн хэрэгсэл, бараа эд юмст хяналт шалгалт хийж бүртгэн хилээр нэвтрүүлэх зориулалтаар тусгайлан тогтоосон газрыг хэлнэ” (Монгол Хятадын хилийн боомт тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, 2004)

Дээрх тодорхойлолтуудад дүгнэлт хийхэд: Хилийн боомт гэдэг нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг тусгайлан төхөөрөмжилсөн газраар шалгах үйл ажиллагааг явуулдаг газар гэж тодорхойлж байна.

Хүн төрөлхтөн хөгжихийн хэрээр хувь хүн, нийгэм, иргэншлийн аюулгүй байдлын асуудал улам хурцдаж, ялангуяа Дэлхийн I дайны дараахан гарсан улс төр, нийгмийн их хувьсал өөрчлөлтийн улмаас энэ асуудал дэлхий нийтийн анхаарлын төвд орж эхэлсэн. XX зууны сүүл үеэс аюулгүй байдлын асуудал зөвхөн улс орнуудын төдийгүй дэлхий нийтийн хэмжээнд хамаарах болсон. Аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь учирч болзошгүй аюул, заналыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, няцаах, устгах зэрэг цогц арга хэмжээнд тулгуурладаг бөгөөд энэ нь хувь хүн, нийгэм, улс орон, олон улсын хамтын нийгэмлэгийн хамтын хүчин чармайлтад үндэслэдэг. Иймээс аюулгүй байдлыг судлах нь шинжлэх ухааны олон салбарыг хамарсан, өвөрмөц судлагдахуун бүхий шинжлэх ухааны чиглэл юм.

Аюулгүй байдал гэдэг нь олон салбарт хэрэглэгддэг нийтлэг ойлголт бөгөөд хүрээг нь өргөнөөр хамардаг. В. Далийн тайлбар тольд энэ ойлголтыг “Аюулгүй байдал нь бүрэн бүтэн, найдвартай итгэлтэй байхыг илэрхийлнэ” гэж тодорхойлсон бол, Я. Цэвэлийн тайлбар тольд “Айдас, болгоомжлол





МОНГОЛ УЛСЫН
ХИЛ СУДЛАЛ

шаардлагагүй, аюулгүй нөхцөл” гэж тайлбарлажээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж (цаашид үндэсний аюулгүй байдал гэх) улс орныхоо үндэсний язгуур ашиг сонирхлыг хангахуйц гадаад, дотоодын тогтвортой, баталгаатай орчныг бүрдүүлсэн төлөв хэмээн тодорхойлдог. Харин үндэсний язгуур ашиг сонирхолд Монгол Улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмний оршин тогтнол ба соёл иргэншил, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөөний баталгаат байдал, эдийн засгийн тогтвортой хөгжил, экологийн тэнцвэрт орчин зэрэг ордог гэж Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд тусгасан байдаг. (Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2010)

Үүнтэй нийцүүлэн “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэдэг нь үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах таатай гадаад, дотоод орчин бүрдсэн байхыг хэлнэ” гэж тодорхойлсон байна. (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010)

Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хязгаарын хүрээнд төр, нийгэм, иргэдийн эрх ашиг бүрэн хамгаалагдсан байдлыг илтгэнэ. Энэ нь нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдлыг хадгалах, төрийн тусгаар тогтнолыг хамгаалах, хуулийн этгээд болон иргэдийн улсын хил, хил орчмын дэглэм, хилийн боомтод мөрдөх журмыг чанд сахих, төрийн байгууллагууд болон хилийн аюулгүй байдлыг хангах хүчний чадавхыг бэхжүүлэх, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх замаар хангагддаг.

Хилийн аюулгүй байдлын салшгүй хэсэг болох хилийн боомтын аюулгүй байдал нь тухайн боомтоор улсын хил нэвтгэрч буй зорчигч, тээврийн хэрэгсэл, хилийн хяналтын байгууллагын албан хаагч, мөн боомтод үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчид гэмт халдлагад өртөхгүй байх нөхцөл бүрдсэн байдлыг илэрхийлдэг.

Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь хилийн хяналтын

байгууллагуудын хяналт шалгалтын хэвийн ажиллагааг хангах, дэг журам сахиулах, хууль бус үйлдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, онцгой нөхцөл байдал үүсэхэд хэрэгжүүлэх цогц арга хэмжээг багтаадаг гэж Хилийн тухай хуульд заасан байна. (Хилийн тухай хууль, 2016)

Ийнхүү хууль тогтоомжид зааснаар хилийн болон боомтын аюулгүй байдал нь хоорондоо нягт уялдаатай бөгөөд нэг нь нөгөөгийнхөө баталгаа болдог. Харин боомтод зорчигч болон хилийн хяналтын байгууллагын албан хаагчдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд заналхийлэл учирч, боомтын хэвийн үйл ажиллагаа доголдох үед боомтын аюулгүй байдал алдагдаж, онцгой нөхцөл байдал үүсэх үндсэн шалтгаан болдог.

Онцгой нөхцөл байдлын тухай ойлголт: Аюулгүй байдлын ухаан нь хүн төрөлхтөн, нийгмийн тогтолцоо, төр улс болон байгаль дэлхий зэрэг оршихуйг бүрдүүлэгч үндсэн элементүүдийн аюулгүй байдлыг хамгаалж, тэдгээрийн тогтвортой, зохистой хөгжлийг дэмжихэд чиглэсэн онол, арга зүйн цогц мэдлэгийн салбар юм. Тэр дундаа онцгой нөхцөл байдал үүсэх эрсдэл, аюул, заналын шинж чанар нь цаг үеийн өөрчлөлт, даяаршлын нөлөөн дор байнга хувьсаж байдаг тул аюулгүй байдал судлал нь эдгээр нөхцөлд урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, хор уршгийг арилгах арга зүйг судалдаг бие даасан шинжлэх ухааны чиглэл болон төлөвшжээ. Онцгой нөхцөл байдал нь улс орны дотоод, гадаад орчин, нийгэм-эдийн засаг, улс төрийн бодлого, хүрээлэн буй орчны аюулгүй байдал зэрэг олон хүчин зүйлтэй уялдан илэрдэг учраас аюулгүй байдлын судалгааны объект эдгээр бүх хүрээг хамарсан цогц ойлголт гэж үзэх хандлага түгээмэл байна.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд “онцгой нөхцөл байдал” гэсэн ойлголтыг өөрсдийн хууль тогтоомжийн хүрээнд өөр өөр ухагдахуунаар хэрэглэж байна.

Онц байдал зарлахын өмнөх шатны нөхцөл байдлын үед тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан

ажиллагаанд хэрэглэгддэг нэр томьёог авч үзвэл, эрх зүйн зохицуулалтын хүрээнд эдгээр байгууллагууд өөр өөр ойлголтоор хэрэглэж байна. Тухайлбал, Хил хамгаалах, Цагдаагийн болон Зэвсэгт хүчний байгууллагууд “онцгой нөхцөл байдал” гэсэн нэр томьёог хэрэглэдэг бол, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага “хямралт байдал”, Онцгой байдлын байгууллага “гамшиг” гэсэн нэр томьёог тус тус хэрэглэн хууль, эрх зүйн зохицуулалтад тусгасан байдаг.

“Онцгой байдал” гэдэг нь гамшгаас урьдчилан сэргийлэх болон түүнийг арилгах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад төрийн төв байгууллага, холбогдох агентлаг, аж ахуйн нэгж, албан тушаалтнуудын хамтын ажиллагааг уялдуулж зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг тусгай ажиллагаа явагдаж буй нөхцөл байдлыг илэрхийлдэг. (В.Жавхланцогт, Ж.Өвгөнбүргэд, 2017)

Харин “онцгой нөхцөл байдал” гэдэг нь тодорхой газар нутагт осол, байгалийн аюулт үзэгдэл, бусад гамшгийн улмаас хүний амь нас хохирох, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзэх, эдийн засагт их хэмжээний хохирол учрах, хүн амын хэвийн амьдралын нөхцөл алдагдах зэрэг нөхцөл үүссэн байдлыг хэлдэг гэж тодорхойлсон байдаг. (М.Ганболд, 2010)

Хилийн боомтын онцгой нөхцөл байдал гэж хилийн боомтод хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчид, зорчигч, тээврийн хэрэгсэлд, гамшиг, аюулт үзэгдэл тохиолдох, халдварт өвчин тархах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох, зорчигч, тээврийн хэрэгслийг барьцаалах, террорист халдлага үйлдэх нөхцөл байдал бий болж боомтын хэвийн үйл ажиллагаа алдагдахыг хэлнэ гэж судлаачийн хувьд тодорхойлж байна.

Монгол Улс хилийн болон иргэдийн харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр болон хилийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд, хилийн хяналтын байгууллагууд өөрсдийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, боомт дахь дэг журмыг сахиулах, албан хаагчид

болон зорчигчдын аюулгүй байдлыг хангах, мөн боомтод гарч болзошгүй хууль бус үйлдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох үүрэгтэй.

Түүнчлэн, хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд “тусгай дэглэм” тогтоон, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг Хил хамгаалах байгууллага хариуцан зохицуулдаг. Харин хилийн боомтын аюулгүй байдлыг хангах бодит үйл ажиллагааг хилийн отряд (анги)-ийн штаб хэрэгжүүлж, Хилийн цэргийн штаб мэргэжлийн удирдлага, чиглэлээр хангадаг.

Хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс:

Хилийн боомтын онцгой нөхцөл байдал нь улсын хилээр нэвтрэх үйл ажиллагааны хэвийн горим алдагдаж, аюул, занал, зөрчил, хямралт нөхцөл байдал үүсэхийг илтгэдэг бөгөөд энэ нь олон талт хүчин зүйлсийн нөлөөгөөр бий болдог цогц үзэгдэл юм. Ийм нөхцөл байдлын үүсэл, үр дагавар нь дотоод, гадаад орчны шинж чанар, нийгэм-эдийн засгийн нөхцөл, хууль эрх зүйн зохицуулалт болон хүний хүчин зүйлтэй шууд уялдаатай байдаг.

Нэгдүгээрт: Гадаад орчны хүчин зүйл нь хөрш улс орнуудын улс төр, нийгмийн тогтворгүй байдал, бүс нутгийн зөрчил, зэвсэгт мөргөлдөөн, терроризм, хил дамнасан гэмт хэрэг, хууль бус худалдаа, хүн, зэвсэг, мансууруулах бодисын хууль бус хөдөлгөөн зэрэг олон улсын шинжтэй заналуудаар илэрдэг. Эдгээр нь хилийн боомтын үйл ажиллагаанд саад учруулж, онцгой нөхцөл байдал үүсэх шууд шалтгаан болдог.

Хоёрдугаарт: Дотоод улс төр, нийгмийн хүчин зүйл нь төрийн институцийн тогтвортой байдал, хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо, нийгмийн бухимдал, эдийн засгийн хямрал, авлига, сахилгын зөрчил зэрэгтэй холбоотой байдаг. Эдгээр хүчин зүйл нь онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах чадварыг сулруулж, эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Гуравдугаарт: Байгалийн болон хүрээлэн буй орчны хүчин зүйл нь газар





ХУУЛЬ САХИУЛАХУЙ

хөдлөлт, үер, цасан шуурга, хэт халалт, цар тахал зэрэг гамшгийн шинжтэй үзэгдлүүд юм. Ийм нөхцөл байдал нь боомтын дэд бүтцийн ажиллагааг доголдуулж, хүн, тээврийн урсгалыг хязгаарлах, аюулгүй байдлын тусгай дэглэм тогтоох нөхцөл бүрдүүлдэг.

Дөрөвдүгээрт: Хууль эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээ нь хилийн боомтын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын хоорондын эрх зүйн зохицуулалт, уялдаа холбоо, хамтын ажиллагааны түвшнээс хамаарна. Хэрэв эрх зүйн орчин тодорхой бус, давхардал, хийдэлтэй байвал онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах үр дүн буурдаг.

Тавдугаарт: Хүний хүчин зүйл нь боомтод ажиллаж буй албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хариуцлага, сэтгэлзүйн бэлтгэлжилт болон зорчигчдын хууль сахиу соёл, зан төлөвтэй холбоотой. Хүний хүчин зүйл нь онцгой нөхцөл байдлын илрэл, өрнөл, хариу арга хэмжээний чанарт шууд нөлөөлдөг.

Ингэснээр, хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс нь дан ганц аюулгүй байдлын асуудал биш, харин гаднын занал, дотоод зохион байгуулалтын алдаа, байгалийн хүчин зүйл, хүний болон эрх зүйн орчны уялдаа холбоо бүхий цогц шинжтэй үзэгдэл юм. Иймээс эдгээр хүчин зүйлсийг урьдчилан тодорхойлож, эрсдэлийн үнэлгээ хийх, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах нь боомтын аюулгүй байдлыг хангах үндэс суурь болдог.

Хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүссэн үеийн харилцан ажиллагааны өнөөгийн байдал:

Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан, хамтын ажиллагааны уламжлал нь Монгол Улсад 1933 онд “Хязгаарын цэрэг” байгуулагдсанаар эхэлсэн бөгөөд энэ үеэс хойш тухайн цагийн Монгол Ардын цэргийн нэгтгэл, Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа байгууллагууд болон орон нутгийн захиргааны

байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж ирсэн урт хугацааны туршлагатай. Энэ хамтын ажиллагаа нь хил хамгаалалтын тасралтгүй үйл ажиллагааг хангах, хил орчимд тохиолдох гамшиг, аюулт үзэгдэлд шуурхай арга хэмжээ авах, хилийн зөрчил, будилаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж ирсэн билээ.

Монгол Улс хилийн болон иргэдийн харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр болон Засгийн газрын шийдвэрийн дагуу агаарын 6, төмөр замын 6, авто замын 27, нийт 39 боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан хэрэгжүүлж байна.

Одоогоор Монгол Улсын 7 аймгийн нутаг дэвсгэрт БНХАУ-тай, 8 аймгийн нутаг дэвсгэрт ОХУ-тай хиллэдэг боомтууд байрлаж, эдгээр боомтууд нь гадаад худалдаа, зорчигч тээврийн урсгалын үндсэн гарц болж байна. Хилийн боомтод ажиллаж буй хилийн хяналтын эрх бүхий байгууллагууд нь холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн дагуу хяналт шалгалт, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд нь Засгийн газрын баталсан холбогдох төлөвлөгөөнүүдийг үндэслэн харилцан ажиллагаагаа зохион байгуулдаг. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл үүссэн үед байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах ерөнхий төлөвлөгөө”, мөн 2023 оны 136 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн эмх замбараагүй байдлын улмаас онц байдал тогтоосон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ийг удирдлага болгон ажилладаг.

Хил хамгаалах байгууллага нь дээрх төлөвлөгөөний дагуу төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай “Хилийн зурвас, боомтод онцгой нөхцөл бий болсон үеийн харилцан ажиллагааг зохицуулах чиглэлийн төлөвлөгөө” болон холбогдох бусад хууль, журмын дагуу

харилцан ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, боомтод онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай харилцан ажиллагааг зохион байгуулахад авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь байдлаар тусгасан байна. Үүнд:

-Зэвсэгт Хүчин: Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, бүрэн бүтэн байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад оршино. (Батлан хамгаалах тухай хууль, 2016)

Мөн Зэвсэгт хүчний тухай хуульд зааснаар улсын хил хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг хүлээнэ. (Зэвсэгт хүчний тухай хууль, 2016)

ХХЕГ-ын даргын 2007 оны тушаалаар батлагдсан Хилийн цэргийн штабуудын албаны зааварт Хил хамгаалах байгууллага нь улсын хилийн хамгаалалтыг хүч нэмэгдүүлэх, хилийн операц (эрэл) явуулах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох, зэвсэггүй бөөн иргэд улсын хил зөрчих, зорчигч, тээврийн хэрэгслийг барьцаалах, террорист халдлага, өдөөн хатгалга түрэмгийлэл үйлдэх нөхцөл байдал бий болсон үед дэмжлэг үзүүлэх зорилгоор хил орчимд байрлаж байгаа зэвсэгт хүчний ерөнхий зориулалтын нэгтгэл, ангиудын штабуудтай харилцан ажиллагааг зохион байгуулна. Энэ үед харилцан ажиллагаатай нэгтгэл, ангиудын удирдлагын байр байгаа газар, холбоо зохион байгуулах журам, холбоо, шифр, кодлох хэрэгсэл бүхий шуурхай бүлэг эсвэл төлөөлөгчдийг солилцох журам зэргийг тохиролцон хамтран ажиллана гэж тодорхойлсон байдаг.

-Тагнуулын байгууллага: Хилийн боомтод гарах магадлалтай хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэн таслан зогсоох, мөн онцгой нөхцөл байдал үүссэн үед гүйцэтгэх ажиллагааг тагнуулын хүч хэрэгслүүдтэй хамтран зохицуулж хамгаалах журамд нийцүүлэн хэрэгжүүлэх:

Хилийн бүс, зурваст дайсны тагнуулын байгууллага, тэдгээрийн сүлжээ, бусад дайсагнасан этгээдүүдийг илрүүлж үйл ажиллагааг нь таслан зогсоох журам;

Улсын хил болон хил орчмын бүсэд улсын аюулгүй байдлын эрх ашгийг хамгаалахын тулд харилцан мэдээлэл солилцох, түүний үндсэн дээр шаардлагатай арга хэмжээ авах зэргийг харилцан тохирно.

-Цагдаагийн байгууллага, Дотоодын цэргийн штаб: Цагдаагийн ерөнхий газар, Хилийн цэргийг удирдах газрын дарга нарын 1998 оны 26/114 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Цагдаагийн болон Хил хамгаалах байгууллагын хамтран ажиллах журам", ХЗДХ-ийн сайд, Санхүү, эдийн засгийн сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга нарын 2000 оны 149/114/343 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Хилийн боомтын асуудлаар харилцан ажиллах журам"-д тодорхой тусгасан.

Харилцан ажиллах төлөвлөгөөний дагуу улсын хилийн бүс, зурваст байрлах Цагдаагийн байгууллага, Дотоодын цэргийн анги, салбарууд боомт болон хилийн дэглэм, журмыг сахиулах үйл ажиллагаанд оролцохдоо гүйцэтгэх үүрэг, бүрэлдэхүүн, байрлал, ажиллах журмыг тодорхойлж, уулзах район, хүрэлцэн ирэх цаг, харилцан ажиллах дохио болон ар тал, техникийн хангалтын арга хэмжээг тохиролцоно.

Мөн Цагдаагийн байгууллага, Дотоодын цэргийн анги салбаруудтай хамтран ажиллах хилийн анги, салбарууд дараах зарчмуудыг баримтална:

Хилийн тодорхой хэсэгт хилийн операц, эрэл, хээрийн сургууль, зэвсэгт өдөөн хатгалга, зэвсэггүй олон хүний нэвтрэлтийг саатуулах зэрэг ажиллагаа явуулах үед иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, зохицуулах журам;

Улсын хил хамгаалалт болон хил орчмын нутаг дэвсгэрт хэв журам сахиулах үүднээс мэдээлэл, мэдээ солилцох ажиллагаа;

Хил орчмын бүсэд онцгой нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлэх журам;



МОНГОЛЫН
Дотоодын
Хэрэг
Төрийн
Хүчин



ᠬᠡᠭᠡᠨ ᠰᠠᠬᠢᠭᠠᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

Улсын хилийг хүчээр хамгаалж буй үед хамтран ажиллах журам, хамтарсан эргүүл, харуул, манааны үүргийг хэрэгжүүлэх журам;

Цагдаагийн байгууллагаас хилээр нэвтрүүлэхийг хориглосон этгээдийг саатуулах зэрэг үйл ажиллагааг харилцан тохиролцон, хамтран хэрэгжүүлнэ. (А.Энхтөр, 2022)

Онцгой байдлын байгууллага: Улсын хил, хил орчмын бүсэд байгалийн гамшиг эсвэл онцгой нөхцөл үүссэн тохиолдолд хамтран ажиллах журам, үүрэгт ажлаа хэрэгжүүлдэг. Мөн хил орчмын бүсэд гамшигын улмаас учирч болзошгүй хор хохирлыг арилгах, сэргээн босгох арга хэмжээнд оролцож, болзошгүй аюулын талаарх мэдээллийг харилцан солилцон хамтран ажилладаг.

Гаалийн байгууллага: Улсын хил, боомтоор хууль бус ачаа бараа нэвтрүүлэхийг таслан зогсоох, хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед харилцан зохицон ажиллах, хил дээр дэг журмыг сахиулах, тогтоох зэрэг үүргийг гүйцэтгэнэ. Мөн зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг шалгах, нарийвчилсан хяналт хийх, хорио цээрт хамрагдсан халдварт өвчин, эрүүл мэндэд аюултай барааг хилээр нэвтрүүлэхээс хамгаалах арга хэмжээг хамтран хэрэгжүүлдэг. Улсын хил дээр халдварт өвчний тохиолдолд хорио цээр тогтоох үеийн ажиллагаа, журмыг харилцан тохиролцон хэрэгжүүлнэ.

-Гадаадын иргэн харьяатын байгууллага: Хил хамгаалах байгууллага болон Гадаадын иргэн харьяатын байгууллага нь ХХЕГ, ГИХГ дарга нарын 2011.05.05-ны өдрийн 03/А/157 дугаартай “Мэдээлэл солилцох ажлыг сайжруулах тухай” 04/А/158 дугаартай “Хамтран ажиллах тухай” хамтарсан тушаалын дагуу харилцан ажиллах, мэдээлэл солилцох, холбогдох хууль, журмын дагуу хамтран ажилладаг.

Хөрш орнууд болон гуравдагч орны талаас хууль бус цагаач, дүрвэгсэд, нэрвэгдэгсдийн хөдөлгөөнийг хянах, саатуулах, таслан зогсоох хамтарсан арга хэмжээг хэрэгжүүлэх;

Улсын хил дээр гадаадын иргэд болон харьяат цагаачдад тавих хяналт, тэдний талаарх мэдээллийг харилцан солилцох журам, мөн уг журмыг хэрэгжүүлэх арга замыг зохицуулах;

Улсын хилээр хууль бусаар нэвтэрсэн гадаадын иргэдийг захиргааны журмаар албадан гаргахтай холбоотой асуудлыг хамтран шийдвэрлэх, хэрэгжүүлэх журам тогтоож ажиллана. Мөн хилийн боомтод онцгой нөхцөл байдал үүссэн үед болон бусад үед харилцан ажиллах журмын мөрдөн ажилладаг.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагаа дээрх эрх зүйн зохицуулалтын хүрээнд хэвийн явагдаж байгаа ч бодит байдал дээр дараах **асуудлууд тулгамдаж байна**: Үүнд:

-Хилийн боомтын үйл ажиллагаанд төрөөс баримталж буй бодлого, зохицуулалтын хүрээнд нэгдсэн удирдлага, уялдаа холбоо, хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь салбар хоорондын зохион байгуулалт, дэд бүтцийн хөгжил, тоног төхөөрөмжийн хангалтад сөргөөр нөлөөлж байна. Үүний үр дүнд хилийн хяналт, шалгалтын байгууллагуудын ажиллах нөхцөл бүрэн хангагдаагүй, албан хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгаа дутмаг байгаагаас ажлын үр дүнд, гүйцэтгэл буурч байна.

-Байгууллагуудын харилцан ажиллагаа бодит түвшинд сул. Хилийн хяналтын байгууллагууд нь “Монгол Улсын аюулгүй байдлыг хангах” нийтлэг зорилготой хэдий ч, бодит хэрэгжилтийн түвшинд байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, харилцан хамтын ажиллагаа сул, нэгдсэн зохион байгуулалт, шинжлэх ухааны үндэслэлтэй хандлага дутмаг байна.

-Өнөөгийн нөхцөлд хилийн боомтод ажилладаг төрийн байгууллагууд нь бие даасан босоо удирдлагын тогтолцоотой, нэгдмэл бодлого, удирдлагагүй, эрх зүйн орчны тодорхойгүй байдал давамгайлж байна. Энэ нь байгууллагуудын хамтын ажиллагааг хүндрүүлж, онцгой нөхцөл байдал үүсэх үед нэгдсэн удирдлага, уялдаа

холбоотой хариу арга хэмжээ авах боломжийг хязгаарлаж байна.

-Хилийн боомтуудад онцгой нөхцөл байдал үүссэн үеийн харилцан ажиллах төлөвлөгөөнүүд байдаг ч боомт бүрийн онцлогт тохирсон сургалт, дадлага хангалтгүй, зарим боомтод шаардлагатай техник, холбоо, хамгаалалтын хэрэгсэл дутагдалтай байна.

-Хилийн боомт, тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын мэдээллийн систем уялдаа муутай, аюул илрүүлэх эрт сэрэмжлүүлгийн механизм бүрэн ажиллагаанд орж чадаагүй байгаа зэрэг дутагдлууд байгаа нь практик дээр харагдаж байна.

Хилийн боомтын аюулгүй байдлыг хангахад төрийн байгууллагуудын **харилцан ажиллагааг сайжруулснаар доорх үр дүнд хүрнэ** гэж үзэж байна.

Төрийн байгууллагуудын удирдлага, зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэх нь чухал бөгөөд үүнд хилийн боомтын цогц бодлого боловсруулах, байгууллагуудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хяналт шалгалтын үйл ажиллагааг стандартчилах. Энэ арга замыг хэрэгжүүлснээр боомтын дэд бүтэц, тоног төхөөрөмж, хилийн хяналт шалгалтын үйл ажиллагааны уялдаа сайжирч, албан хаагчдын мэргэжлийн нөхцөл, аюулгүй байдал баталгаатай болно.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. Үүнд байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, харилцан дэмжлэг үзүүлэх, онцгой нөхцөл байдалд шуурхай арга хэмжээ авах журам, сургалт, дадлага хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг системтэйгээр зохион байгуулах шаардлагатай. Ийм арга хэмжээний үр дүнд хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед байгууллагууд нэгдсэн удирдлага, зөв зохицуулалт дор үйл ажиллагаагаа явуулж, эрсдэлийг бууруулах чадвартай болно.

Эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь чухал бөгөөд хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хуулиар тодорхой болгох

шаардлагатай. Энэ нь эрх бүхий байгууллагуудын хоорондын харилцан ажиллагааг хууль ёсны хүрээнд зохицуулж, зохион байгуулалтын хяналт, үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр Монгол Улсын хилийн боомтын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаа, зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг аюулгүй нэвтрүүлэх чадвар нэмэгдэж, онцгой нөхцөлд шуурхай, зохион байгуулалттай арга хэмжээ авч, үндэсний аюулгүй байдлыг тогтвортой хангах боломж бүрдэнэ.

Дүгнэлт

Монгол Улсын хил бол тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа бөгөөд хилийн боомт нь улсын эдийн засаг, олон улсын харилцаа, иргэдийн амьдралд шууд нөлөөлөх стратегийн ач холбогдолтой цэг юм. Онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд боомтын аюулгүй байдал алдагдах нь улсын аюулгүй байдал, зорчигчдын болон албан хаагчдын амь нас, эд хөрөнгөд эрсдэл учруулдаг тул хилийн боомтын хамгаалалт нь оновчтой зохион байгуулалт, нэгдсэн удирдлага, харилцан ажиллагаанд суурилсан байх шаардлагатай. Судалгааны явцад онцгой нөхцөл байдал үүсэх хүчин зүйлс нь дотоод, гадаад, байгалийн болон хүний хүчин зүйлсээс бүрдэж, бие биетэйгээ уялдан эрсдэлийг тодорхойлдог болох нь тогтоогдсон бөгөөд өнөөгийн байдлаар төрийн байгууллагуудын харилцан ажиллагаа тасралтгүй явагдаж ирсэн уламжлалтай боловч удирдлага, сургалт, техник хэрэгслийн хангалт, мэдээллийн системийн нэгдсэн зохицуулалт сул байгаа нь онцгой нөхцөлд шуурхай хариу арга хэмжээ авахад хүндрэл учруулдаг гэж үзэж байна.

Санал

Хилийн боомтын аюулгүй байдлыг бэхжүүлэх, боомтод онцгой нөхцөл үүсэх эрсдэлийг бууруулахад авч хэрэгжүүлбэл үр дүнд хүрнэ гэж үзэж байна:

-Хилийн боомтын үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлж, удирдлага, хяналтын тогтолцоог стандартчилах.





МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХУЙ
ХИЛ СУДЛАЛ

-Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлэх, онцгой нөхцөлд шуурхай арга хэмжээ авах сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулах.

-Боомтын хамгаалалтын тоног төхөөрөмж, холбоо, хамгаалалтын хэрэгслийг шинэчилж, мэдээлэл, дүн шинжилгээний нэгдсэн системийг бүрдүүлэх.

-Хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үед төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хуульчилж, зохицуулалтын нэгдсэн орчныг бүрдүүлэх.

-Хилийн боомтод нөлөөлж болох хүчин зүйлсийг тогтмол үнэлж, эрсдэлийг бууруулах стратеги боловсруулж хэрэгжүүлэх.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр Монгол Улсын хилийн боомтын аюулгүй байдал баталгаажих, зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг аюулгүй нэвтрүүлэх чадвар нэмэгдэж, онцгой нөхцөлд нэгдсэн удирдлага, зохион байгуулалт дор шуурхай арга хэмжээ авч, үндэсний аюулгүй байдлыг тогтвортой хангах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт

А.Энхтөр. (2022). *Монгол Улсын хилийн цэргийн байгуулалтын онол, практикийн асуудал*.

Батлан хамгаалах тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн*

систем. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12122>

В.Жавхланцогт, Ж.Өвгөнбүргэд. (2017). *Хилийн албанд ашиглагдах зарим нэр томъёоны тайлбар толь*.

Зэвсэгт хүчний тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12123>

М.Ганболд. (2010). *Хилийн нэр томъёоны тайлбар толь*.

Монгол Хятадын хилийн боомт тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Б.-ы. З. (2004). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/372>

Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. (2010). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=18>

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. (2010). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/6163>

Х.Асхар. (2024). *Хилийн боомтын үйл ажиллагааны онол, практикийн асуудал*.

Хилийн тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/12418>